МОНГОЛ ШУУДАН

*Үзүүргүй хязгаарт өртөөлөж хүргэнэ...*

# ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

"МОНГОЛ ШУУДАН" ТӨХК




GAULI INVESTMENT SECURITIES

**АЛБАН ЁСНЫ ХАЯГ:**

УБ, СБД, 8-р хороо, Оюутны гудамж, Сонор плаза, № 602
Холбоо барих утас: 70153300
Вэб сайт:www.gauli.mn
Цахим шуудан: info@gauli.mn


2015

# ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

"ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ"-ИЙН 7.1-Д ЗААСНЫ ДАГУУ ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАЖ БУЙ ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

# ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮНДЭСЛЭЛ

**1** Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн "Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" 70 дугаар тогтоол :

> *"Монгол Шуудан" Төрийн өмчит хувьцаат компанийн нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, орлогыг компанийн үйл ажиллагааг сайжруулах эх үүсвэр болгон ашиглах"*

**2** Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн "2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай" 330 дугаар тогтоол :

> *"Монгол Шуудан" ТӨХК- ийн нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, орлогыг компанийн үйл ажиллагааг сайжруулах эх үүсвэр болгон ашиглах"*

**3** Төрийн Өмчийн Хорооны 2015 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн "Нэмэлт хувьцаа гаргах тухай" 594 дүгээр тогтоол:

> *"Монгол Шуудан" төрийн өмчит хувьцаат компанийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх хэмжээний нэмэлт хувьцааг гаргаж, нийтэд анхлан санал болгосугай"*

**4** "Монгол Шуудан" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн "Гэрээ байгуулах тухай" 10/07/09 дугаар тогтоол :

> *"Компанийн төрийн эзэмшлийн нийт хувьцааны 34 хувьд ногдох хэмжээнд нэмэлт хувьцаа гарган арилжаалах, Андеррайтер-зөвлөх үйлчилгээг Андеррайтер, брокер дилерийн тусгай зөвшөөрөл бүхий Гаули хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсүгэй"*

# ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

## ЭВИДЕНСЕ ХХК

ҮНЭЛГЭЭ

| | |
|---|---|
| Хаяг: | УБ хот, ЧД, Зоос гоёл ХК- ийн байр, № 207 |
| Холбоо барих утас: | 9905 - 7121 |
| Цахим шуудан: | valuation@evidenceaudit.mn |

## АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ ХХК

АУДИТ

| | |
|---|---|
| Хаяг: | УБ хот, БЗД, 14-р хороо, Борх төв № 301, 310 тоот |
| Холбоо барих утас: | 1145-0279, 99040059 |
| Цахим шуудан: | Enkhmaa_57@yahoo.com |

## ОДГЭРЭЛ ЭНД ПАРТНЕРС ХУУЛЬ ЗҮЙН ФИРМ

ХУУЛЬ

| | |
|---|---|
| Хаяг: | УБ хот, СБД,8-р хороо, Бээжин 37 GB плаза төв № 602 |
| Холбоо барих утас: | 9903-0076 |
| Цахим шуудан: | bring@mon-intl.mn |

## ГАУЛИ ҮЦК ХХК

АНДЕРРАЙТЕР

| | |
|---|---|
| Хаяг: | УБ, СБД, 8-р хороо, Оюутны гудамж, Сонор плаза, № 602 |
| Холбоо барих утас: | 70153300 |
| Вэб сайт: | www.gauli.mn |
| Цахим шуудан: | info@gauli.mn |

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| КОМПАНИЙН ОНООСОН НЭР : | "МОНГОЛ ШУУДАН" ТӨХК |
| БАЙГУУЛАГДСАН ОГНОО: | 1921 оны 07 сарын 19-ний өдөр |
| КОМПАНИЙН ХЭЛБЭР: | 100% Төрийн Өмчит ХК |
| ТӨВ ОФФИСИЙН АЛБАН ЁСНЫ ХАЯГ : | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Сүхбаатарын гудамж - 9 |
| ШУУДАН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД: | Улаанбаатар хот: 40 шуудан үйлчилгээний салбар<br>Аймгийн төв: 21 шуудан үйлчилгээний газар<br>Сумд: 334 шуудан үйлчилгээний салбар |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ: | Захидал, бичиг, боодол илгээлт, буухиа шуудан зэрэг шуудангийн бүх үйлчилгээ<br>Шуудангийн марк, үнэт цаасны эх зураг хийх, борлуулах<br>Гадаад дотоод тогтмол хэвлэлийн захиалга авах, хүргэх борлуулах<br>Илгээмжийн худалдаа эрхлэх |

"Монгол шуудан" ТӨХК нь анх 1921 онд байгуулагдан шуудангийн салбарт үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 94 жилийн түүхтэй 100 хувь төрийн өмчит "А" ангиллын лиценз бүхий монгол улсын шуудан үйлчилгээний ууган байгууллага юм.
Тус компани нь Монгол Улсын 21 аймаг, 334 сумдын салбар, Улаанбаатар хотын 40 салбарт нийт 20 нэр төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байна.

Үнэт цаас гаргагч "Монгол Шуудан" ТӨХК нь шуудангийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулсан дадлага туршлага, мэргэжлийн боловсон хүчин, техник тоног төхөөрөмж, Монгол Улсыг хамарсан үйлчилгээний шуудангийн өргөн сүлжээ, шуудангийн салбарын зах зээлд боломжит бүх төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа гэх мэт олон давуу талаараа энэхүү салбартаа тэргүүлэгч болж байна.

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

"Монгол шуудан" ТӨХК-ийн дээд удирдлага нь Төлөөлөн Удирдах Зөвлөл бөгөөд төв удирдлагын аппарат нь

**4** үндсэн хэлтэс **3** алба **3** газар

Захирлын зөвлөлийн дэргэдэх хяналтын хэсгээс бүрдэх бөгөөд Улаанбаатар хотын үндсэн 21 ШҮС, тэдгээрийн харъяанд үйл ажиллагаа явуулдаг 19 подсалбар, 21 аймгийн төвийн ШҮГ, 334 сумдын ШҮС-т өнөөдрийн байдлаар

**895** хүн ажиллаж байгаагаас

**373** хотод хүн

орон нутагт **522** хүн ажиллаж байна

## НИЙТ АЖИЛЧДЫГ НАС, ХҮЙСЭЭР НЬ ХАРЬЦУУЛБАЛ

**63%** **37%**

**25 хүртэлх насны хүн -13%, 26-35 насны хүн-37%, 36-45 насны хүн 26%, 46-аас дээш насны хүн-24%-ийг эзлэж байна.**

## НИЙТ ШУУДАНЧДЫН

**66%** хөдөө орон нутагт

**29%** УБ хотын ШҮС-т

**5%** захиргаа удирдлагын аппаратад

Шууданчдын 61% нь тусгай дунд болон бүрэн дунд, 31% нь дээд боловсролтой, харин 8% нь дунд болон бага дунд боловсролтой ажилчид байна.

# ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ

## I. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

| № | Албан тушаал | Овог нэр | Хувьцаа эзэмшдэг эсэх |
|---|---|---|---|
| 1 | ТУЗ-ын дарга | О. Сэр-Од | Үгүй |
| 2 | ТУЗ-ын хараат бус гишүүн | Б.Амарсанаа | Үгүй |
| 3 | ТУЗ-ын хараат бус гишүүн | Л. Оюун | Үгүй |
| 4 | ТУЗ-ын хараат бус гишүүн | Б. Мөнхбаяр | Үгүй |
| 5 | ТУЗ-ын гишүүн | Д.Болдмягмар | Үгүй |
| 6 | ТУЗ-ын гишүүн | Д. Нарангэрэл | Үгүй |
| 7 | ТУЗ-ын гишүүн | Ч. Даваажамц | Үгүй |
| 8 | ТУЗ-ын гишүүн | Д. Дэлгэрмаа | Үгүй |
| 9 | ТУЗ-ын гишүүн | Б. Мөнхтулга | Үгүй |
| 10 | ТУЗ-ын нарийн бичиг | Б. Цолмон | Үгүй |

## II. КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, ХЭЛТЭС БОЛОН АЛБАДЫН ДАРГА НАР, ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Овог нэр | Албан тушаал | Хувьцаа эзэмшдэг эсэх |
|---|---|---|---|
| 1 | Ц. Батсайхан | Гүйцэтгэх захирал | Үгүй |
| 2 | А. Шарав | Тэргүүн дэд захирал | Үгүй |
| 3 | Б. Уянга | Захиргаа удирдлагын хэлтсийн дарга | Үгүй |
| 4 | Б. Цэцэндаваа | Төлөвлөлт эдийн засгийн хэлтсийн дарга | Үгүй |
| 5 | Ө. Сугар | Санхүүгийн хэлтсийн дарга | Үгүй |
| 6 | Б.Содчимэг | Шуудангийн ашиглалт, технологийн газрын дарга | Үгүй |
| 7 | Д. Ганболд | Маркийн газрын дарга | Үгүй |
| 8 | Д. Туваан | Дотоод хяналтын албаны дарга | Үгүй |
| 9 | А. Жаргал | Гадаад харилцаа хамтын ажиллагааны газрын дарга | Үгүй |
| 10 | Б. Бат-Өлзий | Хангамж үйлчилгээний албаны дарга | Үгүй |

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТУХАЙ

Үнэт цаас гаргагч компанийн дүрмийн 1.4-д тус компани нь 100 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосон төрийн байгууллага байна хэмээн заажээ. Иймд Төрийн өмчийн хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байна.

| Компанийн нэр | Хувийн эзэмшил | Төрийн эзэмшил | Хэлбэр |
|---|---|---|---|
| "Монгол Шуудан" | 0% | 100% | ТӨХК |

# "МОНГОЛ ШУУДАН" ТӨХК-ИЙН ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭ

"Монгол Шуудан" ТӨХК нь 20 нэр төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдгээс доорх 6 төрлийн үндсэн үйлчилгээнүүд нь орлогын ихэнх хувийг бүрдүүлдэг.

- Хэвлэл захиалга
- Албан бичиг хүргэлт
- Үнэт цаас, маркны борлуулалт
- Ачаа тээврийн үйлчилгээ
- Хүргэлтийн үйлчилгээ
- Илгээлт, буухиа шуудангийн үйлчилгээ

## ОРЛОГЫН БҮТЭЦ

| № | ОРЛОГЫН ТӨРӨЛ | 2014б /Сая. төг/ | Нийт орлогод эзлэх % |
|---|---|---|---|
| 1 | Марк борлуулсны орлого | 806.61 | 7.25% |
| 2 | Үнэт цаасны орлого | 290.39 | 2.61% |
| 3 | Баталгааны орлого | 292.43 | 2.63% |
| 4 | Зээл албан бичгийн орлого | 1,096.27 | 9.85% |
| 5 | Боодлын орлого | 284.63 | 2.56% |
| 6 | Илгээлтийн орлого | 1,188.95 | 10.68% |
| 7 | Буухиа шуудангийн орлого | 723.94 | 6.51% |
| 8 | Шуудангийн хайрцагны орлого | 151.12 | 1.36% |
| 9 | Хүргэлтийн үйлчилгээний орлого | 1,058.84 | 9.51% |
| 10 | Зорчигч тээврийн орлого | 367.75 | 3.30% |
| 11 | Илгээмжийн барааны шимтгэлийн орлого | 146.12 | 1.31% |
| 12 | Хэвлэлийн шимтгэлийн орлого | 651.93 | 5.86% |
| 13 | Хэвлэлийн хүргэлтийн орлого /жингийн/ | 444.15 | 3.99% |
| 14 | Улс хоорондын тооцоо | 2,475.27 | 22.24% |
| 15 | Логистик | - | 0.00% |
| 16 | Бусад | 1,149.93 | 10.33% |
| 17 | Нийт орлого | 11,128.33 | 100.00% |
| 18 | Буцаалт хөнгөлөлт | (187.32) | |
| 19 | Цэвэр борлуулалтын орлого | 10,941.01 | |

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| БАЛАНС | 2010Б | 2011Б | 2012Б | 2013Б | 2014Б |
|---|---|---|---|---|---|
| Эргэлтийн хөрөнгө | | | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 2,251.83 | 2,885.69 | 2,409.58 | 2,551.94 | 2,907.83 |
| Дансны авлага | 653.35 | 757.70 | 2,035.79 | 1,866.76 | 2,192.44 |
| Бараа материал | 1,295.19 | 1,326.25 | 1,529.48 | 1,524.07 | 1,570.80 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 378.20 | 137.88 | 248.27 | 240.63 | 275.54 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 128.34 | 171.76 | (322.18) | 190.51 | 331.46 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **4,706.91** | **5,279.28** | **5,900.94** | **6,373.91** | **7,278.07** |
| Эргэлтийн бус хөрөнгө | | | | | |
| Үндсэн хөрөнгө | 7,332.72 | 7,952.36 | 8,797.98 | 9,815.20 | 11,063.05 |
| Хуримтлагдсан элэгдэл - үндсэн хөрөнгө | (2,092.76) | (2,311.98) | (1,324.94) | (1,851.84) | (2,477.38) |
| Биет бус хөрөнгө | 52.65 | 55.35 | 55.35 | 122.73 | 341.99 |
| Хуримтлагдсан элэгдэл - биет бус хөрөнгө | (26.02) | (30.75) | (35.73) | (89.26) | (56.76) |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | 0.64 | 0.64 | 0.64 | 0.50 | 0.50 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **5,267.24** | **5,665.62** | **7,493.31** | **7,997.33** | **8,871.39** |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **9,974.15** | **10,944.90** | **13,394.25** | **14,371.24** | **16,149.46** |
| Өр төлбөр | | | | | |
| Дансны өглөг | 920.43 | 927.43 | 1,198.19 | 1,229.08 | 1,294.48 |
| Банкны богино хугацаат зээл | - | - | - | - | - |
| Урьдчилж орсон орлого | 1,018.46 | 859.32 | 627.37 | 602.80 | 715.33 |
| Урт хугацаатай зээлийн хүү | - | - | - | - | - |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 380.03 | 309.38 | 314.07 | 317.07 | 214.17 |
| Урт хугацаат өр төлбөр | - | - | - | - | - |
| **Нийт өр төлбөр** | **2,318.93** | **2,096.13** | **2,139.63** | **2,148.95** | **2,223.98** |
| Эздийн өмч | | | | | |
| Хувьцаат капиталын дүн | 616.49 | 3,763.65 | 6,572.70 | 6,572.70 | 6,572.70 |
| Нэмж төлөгдсөн капитал | - | - | - | - | - |
| Дахин үнэлгээний нөөц | 2,477.94 | 2,477.94 | 3,379.92 | 3,379.92 | 3,379.92 |
| Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг | 1,443.65 | - | 895.50 | 1,693.12 | 2,724.47 |
| Хуримтлагдсан ашиг /алдагдал/ | 3,117.15 | 2,607.18 | 406.50 | 576.55 | 1,248.40 |
| **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **7,655.22** | **8,848.77** | **11,254.62** | **12,222.29** | **13,925.49** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **9,974.15** | **10,944.90** | **13,394.25** | **14,371.24** | **16,149.46** |

Эх сурвалж: Монгол Шуудан ТӨХК

# ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сая төгрөг

| ОРЛОГЫН ТАЙЛАН | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 |
|---|---|---|---|---|---|
| Цэвэр борлуулалтын орлого | 4,757.30 | 6,665.80 | 8,290.65 | 8,934.33 | 10,941.01 |
| Борлуулалтын өртөг | 1,435.85 | 5,666.05 | 7,354.27 | 7,997.02 | 9,597.94 |
| Нийт ашиг ( алдагдал) | 664.74 | 999.75 | 936.37 | 937.32 | 1,343.07 |
| Үйл ажиллагааны зардал | 771.11 | (113.38) | 564.62 | 625.62 | 513.74 |
| Үйл ажиллагааны ашиг | 81.86 | 1,113.13 | 371.75 | 311.69 | 829.33 |
| Орлогын татварын зардал | 689.25 | 56.42 | 77.23 | 40.89 | 90.49 |
| Цэвэр ашиг | | 1,056.71 | 294.52 | 270.81 | 738.84 |
| МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН | 622.63 | | | | |
| Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | - | 633.86 | (476.11) | 233.25 | 705.10 |
| Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ | - | - | - | (2.53) | (308.58) |
| Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ | 622.63 | - | - | (88.36) | (40.62) |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | | 633.86 | (476.11) | 142.36 | 355.89 |

# АУДИТЫН ДҮГНЭЛТ

"Ай Жэй Эй Эйч Аудит" ХХК нь Монгол Шуудан ТӨХК-ийн 2015 оны 9-р сарын 30-ны байдлаар санхүүгийн тайланд аудит хийсэн. Аудитын компаны дүгнэлт нь:

Бидний аудитлагдсан санхүүгийн тайлан нь "Монгол шуудан" ТӨХК-ийн 2015 оны 09-р сарын 30-ны өдрөөрх санхүүгийн байдал,тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоо нь НББОУС-д нийцсэн тайлан гаргах шаардлага, Хувь нийлүүлэгчдийн хөрөнгө болон түүний үр ашигт байдлыг хангаж байна.

## Санхүүгийн байдлын тайлан

2015 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар

| | Тэм | 2014 | 2015 |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| Эргэлтийн хөрөнгө | | | |
| Мөнгөн хөрөнгө | 3 | 2,907,833.3 | 1,773,685.1 |
| Авлага | 4 | 2,523,901.9 | 3,403,004.6 |
| Бараа материал | 5 | 1,570,796.6 | 1,641,895.3 |
| Урьдчилж төлсөн зардал / тооцоо / | 6 | 275,537.5 | 208,166.1 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | | 7,278,069.2 | 7,026,751.1 |
| Эргэлтийн бус хөрөнгө | | | |
| Үндсэн хөрөнгө,цэвэр | 7 | 8,585,668.9 | 8,338,203.0 |
| Биет бус хөрөнгө | 8 | 285,226.0 | 267,323.0 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 9 | 500.0 | 500.0 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | | 8,871,394.9 | 8,606,026.0 |
| Нийт хөрөнгийн дүн | | 16,149,464.1 | 15,632,777.1 |
| Өр төлбөр | | | |
| Богино хугацаат өглөг | 10 | 1,307,050.2 | 1,450,678.2 |
| Цалингийн өглөг | | 400.1 | 804.1 |
| НДШ-ийн өглөг | | 33.8 | 2,296.6 |
| Татварын өглөг | | 21,263.5 | 35,358.9 |
| Хүүний өглөг | | - | - |
| Бусад өглөг | | 186,968.4 | 91,336.5 |
| Урт хугацаат зээл | | - | - |
| Урьдчилж орсон орлого | | 708,261.8 | 291,523.5 |
| Өр төлбөрийн нийт дүн | | 2,223,977.8 | 1,871,997.8 |
| Өмч /төрийн / | 11 | 6,572,700.0 | 6,572,700.0 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 12 | 3,379,919.5 | 3,379,919.5 |
| Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг | | 2,724,469.0 | 2,750,469.0 |
| Хуримтлагдсан ашиг, (алдагдал) | | 1,248,397.8 | 1,057,690.8 |
| Тайлангийн үеийн | 13 | 671,847.4 | (190,707.0) |
| Өмнөх үеийн | 13 | 576,550.4 | 1,248,397.8 |
| Өмчийн дүн | | 13,925,486.3 | 13,760,779.3 |
| Нийт өр төлбөр, өмчийн дүн | | 16,149,464.1 | 15,632,777.1 |

## Дэлгэрэнгүй орлогийн тайлан

| | Тэм | 2014 | 2015 |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 14 | 10,941,011.8 | 7,199,241.0 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | | 9,597,942.3 | 6,835,050.7 |
| Нийт ашиг | | 1,343,069.5 | 364,190.3 |
| Бусад орлого | | - | 40,966.9 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 15 | 517,836.8 | 367,076.8 |
| Ханшийн зөрүүгийн олз гарз | | 51,882.8 | 7,361.6 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз гарз | | 29,815.8 | 63.6 |
| Бусад ашиг /алдагдал/ | | (77,600.8) | (68,900.9) |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | | 829,330.5 | (23,458.3) |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 16 | - | - |
| Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал) | | 829,330.5 | (23,458.3) |
| Орлогын албан татвар зардал | 17 | 90,486.6 | 4,948.1 |
| Цэвэр ашиг (алдагдал) | | 738,843.9 | (28,406.4) |

# БИЗНЕС БА ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

"Эвиденсе" ХХК нь үнэлгээний тайлангийнхаа 2-р бүлэгт Монгол шуудан ТӨХК-ийн балансад санхүүгийн шинжилгээ хийн, дүгнэлт гаргаж, 3-р бүлэгт зах зээлийн жишиг үнийн хандлага, цэвэр хөрөнгөнд суурилсан хандлага, орлого капиталжуулалтын хандлагад суурилсан бизнесийн үнэлгээг тус тус тодорхойлжээ. "Эвиденсе" ХХК-ийн дүгнэлт нь:

**Зах зээлийн жишиг үнийн хандлагаарх үнэлгээ нь:**

1. Саявтархан /ойрын 3 сард/ зах зээлд борлогдсон ижил төстэй бизнес байгаагүй.
2. Харьцуулагдаж буй компаниуд эрхлэх үйл ажиллагааныхаа чиглэлээр ойролцоо ч зах зээлд эзлэх хувь, үзүүлж байгаа үйлчилгээний нэр төрөл, үйлчилж байгаа зах зээлийн хамрах хүрээ, бүх нийтийн үйлчилгээний үүрэг, үйл ажиллагаа явуулсан хугацаа, ажилчдын тоо, хуримтлуулсан туршлага, өмчийн хэлбэр, байршил зэргээрээ харьцуулагдашгүй юм.
3. Тус компани олон нийтэд хувьцаагаа арилжаалдаг нээлттэй компани бус тул зах зээлийн жишиг үнийн аргад ашигласан үржүүлэгчдийг ашиглан үнэлгээг үндэслэлтэй гэж үзэх боломжгүй байна.
4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн үржүүлэгч нь компанийн бизнесийн үйл ажиллагааг хангалттай хэмжээнд төлөөлж чадах үзүүлэлт болохгүй.

Дээрх шалтгаануудын улмаас хангалттай нотолгоогүй учир зах зээлийн жишиг үнийн хандлагаарх үнэлгээг ашигласангүй.

Балансын цэвэр активд суурилсан хөрөнгийн үнэлгээ нь голдуу санхүүгийн тайлагнал болоод бодит хөрөнгийг тодорхойлох зориулалтаар ашиглагддаг, харин тухайн хөрөнгийн ашиглалтаас ирээдүйд олохоор хүлээгдэж байгаа цэвэр ашиг болон цэвэр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр тооцсон бизнеийн үнэлгээ нь хөрөнгө оруулалтын зориулалтаар ашиглагдах нь түгээмэл байдаг.

**Үнэлгээний хандлага бүрээрх хөрөнгийн үнэ цэнийг нэгтгэн хүснэгтээр харуулбал:**

| БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ | |
|---|---|
| БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗАМ | ТУХАЙЛСАН ҮНЭ ЦЭНЭГ |
| ОРЛОГО КАПИТАЛЖУУЛАЛТЫН ХАНДЛАГА | 18,423,477.56 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨД СУУРИЛСАН ҮНИЙН ХАНДЛАГА | 17,282,278.26 |
| ЗАХ ЗЭЭЛИЙН ЖИШИГ ҮНИЙН ХАНДЛАГА | 17,176,642.76 |
| БИЗНЕСИЙН ҮНЭ ЦЭНЭ | 18,423,477.56 |

Энэ түгээмэл жишиг болон захиалагчийн хийлгэж байгаа үнэлгээний зориулалтыг харгалзан Монгол шуудан ТӨХК-ийн бизнесийн үнэлгээг хийхдээ "Орлогын хандлага"-аарх үнэлгээгээр авав. Ийнхүү Монгол шуудан ТӨХК-ийн 2015 оны 09 дүгээр сарын 30-ны үнэлгээний өдрөөрх бизнесийн үнэ цэнийг 18,423,477.56 мянган төгрөг (Арван найман тэрбум дөрвөн зуун хорин гурван сая дөрвөн зуун далан долоон мянга таван зуун жаран төгрөг) болж байгааг тодорхойлж, үнэлгээний тайлан, түүний хавсралт тооцоог захиалагчид хүргүүлж байна.

# НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| Үнэт цаасны нэр : | "Монгол Шуудан" ТӨХК |
| Хувьцааны төрөл : | Энгийн |
| Үнэт цаасны хэлбэр : | Биет бус |
| Үнэт цаасны нэрлэсэн үнэ : | 100 төгрөг |
| Үнэт цаасны нийт тоо ширхэг : | 99,586,363 |
| Анхдагч зах зээлд олон нийтэд санал болгох үнэт цаасны нийт тоо ширхэг (%) : | 34% |
| Арилжааны хэлбэр: | Захиалгын бүртгэлийн арга |
| Захиалгын бүртгэлийн аргаар санал болгох үнэт цаасны тоо ширхэг (%) : | 33,859,363 |
| Олон нийтэд санал болгох үнэ : | 185 төгрөг |
| Татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээ : | 6,263,982,155 төгрөг |

## НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАСНЫ ДАРААХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

| № | ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ | НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАХААС ӨМНӨ | | НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАСНЫ ДАРАА | |
|---|---|---|---|---|---|
| | | ХУВЬЦААНЫ ТОО | ЭЗЛЭХ ХУВЬ | ХУВЬЦААНЫ ТОО | ЭЗЛЭХ ХУВЬ |
| 1 | ТӨРИЙН ӨМЧ | 65,727,000.00 | 100.00% | 65,727,000.00 | 66.00% |
| 2 | ОЛОН НИЙТ | - | - | 33,859,363.00 | 34.00% |
| 3 | НИЙТ | 65,727,000.00 | 100.00% | 99,586,363.00 | 100.00% |

### НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАХААС ӨМНӨ




### НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАСНЫ ДАРАА



## ҮНЭТ ЦААСЫГ ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭ

1. Монгол Шуудан ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2015 оны 12 сарын 10-ны өдрийн 11/13/14 дугаар тогтоолоор анхдагч зах зээлд олон нийтэд санал болгох доод үнийг 185 төгрөг байхаар тогтоосон.

## ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАХИАЛГА ӨГӨХ ТУХАЙ

1. Захиалгыг брокер дилерийн компаниар дамжуулан хүлээн авах бөгөөд хүлээн авсан захиалгыг өдөр бүр арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон цагт арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны ердийн арилжааны захиалгыг арилжааны програмд бүртгэн авдагтай нэгэн адилаар бүртгэнэ.
2. Тухайн үнэт цаасыг худалдан авахыг сонирхогч этгээд нь захиалгыг бүртгэх хугацаанд тодорхой үнээр, тодорхой тооны үнэт цаас худалдан авахаар захиалга өгч болно.
3. Харилцагч нь өндөр үнээр үнэт цаас худалдан авах захиалга өгч болно.
4. Харилцагч захиалга бүртгэх хугацаанд өөрийн өгсөн захиалгын тоо ширхэг үнийн дүнд өөрчлөлт оруулж болохоос гадна цуцалж болно.

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХИАЛГА БАТАЛГААЖУУЛАХ БОЛОН ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ МӨНГИЙГ БАЙРШУУЛАХ ТУХАЙ

"ҮЦТТТХТ" ХХК дахь үнэт цаасны дансандаа мөнгөө байршуулахдаа дотоод, гадаадын аль ч арилжааны банкнаас шилжүүлж болох бөгөөд дансны дугаар нь 12 оронтой байна.

Үнэт цаасны дансандаа хувьцааны мөнгөө байршуулах зааварчилгааг харуулав.
/ 59-4444 дугаартай харилцагч Г. Болдын "Үнэт Цаас Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төв" дэх үнэт цаасны дансандаа 100,000 төгрөг байршуулсан зааварчилгаа /

| | |
|---|---|
| Банкны нэр / Bank name | Огноо / Date: |
| ҮЦТТТХТ | 12/25/2015 |
| Дансны дугаар / Account Number: | Валютын код / Current code: |
| 0059 0000 4444 (0059 — ГАУЛИ ҮЦК Код; 4444 — Таны дансны дугаар) | |
| Хүлээн авагчийн нэр / Account holder: | Гүйвуулгын код / Code: |
| Г. Болд | |
| Гүйлгээний дүн / Transaction Amount | Гүйлгээний утга / Description: |
| 100,000 | Хувьцааны мөнгө |

## ҮНЭТ ЦААСНЫ ХУВААРИЛАЛТЫН ДҮНГ ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ

Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн 'Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам'-ын 6-р зүйлд заасны дагуу арилжаа явагдсан өдөр бүр анхдагч зах зээлийн арилжааны мэдээг олон нийтэд

- МХБ-ийн www.mse.mn
- "Монгол Шуудан" ТӨХК-ийн www.mongolpost.mn
- ГАУЛИ ҮЦК ХХК- ийн www.gauli.mn сайтаар дамжуулан тогтмол хүргэнэ.

# НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

## 1. Эзэмшигчийн өмчөөр тооцсон нэгж хувьцааны дансны үнэ

Олон нийтэд санал болгох үнэ тогтоохын өмнөх улирал буюу 2015 оны 9-р сарын 30-ны байдлаарх аудитын залруулга хийгдсэн санхүүгийн тайланд "Эзэмшигчдийн өмчийн дүн" 13,760,779,300 төгрөг байна. Үүнийг үнэт цаас шинээр гаргахын өмнөх хувьцааны тоо ширхэг буюу 65,727,000-д хуваан тооцоход нэгж хувьцааны "Дансны үнэ" 209.36 төгрөгтэй тэнцэж байна.

| Эзэмшигчдийн өмчийн дүн | 13,760,779,300.00 |
|---|---|
| Хувьцаа тоо | 65,727,000.00 |
| Дансны үнэ | 209.36 |

## 2. Цэвэр хөрөнгийн үнэ цэнийг аргаар тооцсон нэгж хувьцааны үнэ цэнэ

"Эвиденсе" ХХК үнэлгээний компани нь үнэт цаас гаргагчийн "Бизнесийн болон Хөрөнгийн" үнэлгээг 2015 оны 9-р сарын 30-ны байдлаар олон улсын үнэлгээний стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тус үнэлгээгээр "Монгол Шуудан" ТӨХК-ийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг 17,250,712,468.80 төгрөг хэмээн үнэлсэн бөгөөд үүнд үндэслэн тооцоход нэгж хувьцааны "цэвэр хөрөнгийн үнэ цэнэ" нь 262.46 төгрөг болж байна.

Төгрөг

| Цэвэр хөрөнгийн үнэ цэнэ | 17,282,278,260 |
|---|---|
| Хувьцаа тоо | 65,727,000.00 |
| Нэгж хувьцаанд ногдох цэвэр үнэ цэнэ | 262.94 |

## 3. Зах зээлийн жишиг үнийн аргаар тооцсон нэгж хувьцааны үнэ цэнэ

"Эвиденсе" ХХК үнэлгээний компани нь үнэт цаас гаргагчийн "Бизнесийн болон Хөрөнгийн" үнэлгээг 2015 оны 9-р сарын 30-ны байдлаар олон улсын үнэлгээний стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тус үнэлгээгээр "Монгол Шуудан" ТӨХК-ийн зах зээлийн жишиг үнийн аргаар тооцсон бизнесийн үнэлгээ 17,176,642,760 төгрөг хэмээн үнэлсэн бөгөөд үүнд үндэслэн тооцоход нэгж хувьцааны үнэ цэнэ 261.33 төгрөг болж байна.

Төгрөг

| Зах зээлийн жишиг үнийн хандлагаар хийсэн бизнесийн үнэ цэнэ | 17,176,642,760 |
|---|---|
| Хувьцаа тоо | 65,727,000.00 |
| Нэгж хувьцаанд ногдох цэвэр үнэ цэнэ | 261.33 |

Харин одоо үнэт цаасыг олон нийтэд санал болгох үнийг 185 төгрөгөөр тогтоон 33,859,363.00 ширхэг хувьцааг нэмж гаргаснаар нэгж хувьцааны үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөхийг авч үзье.

### Дансны үнийн өөрчлөлт

Төгрөг

| Үзүүлэлт | Хувьцааны тоо | Эзэмшигчдийн өмчийн дүн | Дансны үнэ |
|---|---|---|---|
| 2015.09.30-ны байдлаар | 65,727,000.00 | 13,760,779,300.00 | 209.36 |
| Нэмж гаргах хувьцааны тоо | 33,859,363.00 | 6,263,982,155.00 | 185.00 |
| Нийт | 99,586,363.00 | 20,024,761,455.00 | 201.08 |

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ

Төслийн үндэслэл:

Тээврийн зардал бүтээгдэхүүний үнэд хүчтэй нөлөөлдөг: Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийхээ 62% хувийг импортоор авдаг манай улсын хувьд бүтээгдэхүүний үнэд тээврийн зардал өндөр хувийг эзэлж байна. Энэ нь зардал багатай, найдвартай, түргэн шуурхай, Монголын аль ч аймагт тогтмол тээвэрлэлт хийдэг логистикийн үйлчилгээ Монголд хөгжөөгүйтэй холбоотой юм. Үүнээс үүдэн өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ өндөр тогтох, хэлбэлзэл их байдаг нь иргэдийн нуруунд нэмэлт ачааг үүрүүлж худалдааны салбарт дарамт учруулдаг. Харин логистик хөгжиснөөр уг асуудал шийдэгдэх юм.

Уламжлалт шуудангийн үйлчилгээний зах зээлийн өсөлт хязгаарлагдмал: Ирэх 3 жилийн хугацаанд уламжлалт шуудангийн үйлчилгээг өргөжүүлж компанийн орлогыг нэмэгдүүлэх боломж харагдаж байгаа ч урт хугацаанд өсөлт хязгаарлагдах эрсдэлтэй байна. Ийм нөхцөлд дэлхийн шуудангийн компаниудын хөгжлийн чиг хандлагыг даган логистикийн үйлчилгээний зах зээлд нэвтрэх нь компанийн хөгжилд өндөр ач холбогдолтой юм. Логистикийн үйлчилгээг эрхэлснээр зөвхөн ачаа тээвэрлэхээс гадна шуудангийн үндсэн үйлчилгээгээ хүргэх өргөн сүлжээ бий болдог давуу талтай. Энэхүү сүлжээг бий болгосноор компани хөдөө орон нутагт тогтмол хүрч үйлчлэх боломж бүрдэж нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа найдвартай биелүүлж чадна.

Авто замын хөгжил: 2012 оноос Монголын засгийн газар бүх аймгуудыг хатуу хучилттай авто замаар холбох ажлыг эхлүүлж 2,967 км авто замын уртыг 2,655 км-ээр нэмж 5,622 км урт болгож чадлаа. Ингэснээр 15 аймаг хатуу хучилттай авто замаар Улаанбаатар хоттой холбогджээ. Дэд бүтцийн энэхүү хөгжил нь "авто замын логистикийн үйлчилгээ"-г орон даяар нэвтрүүлэх боломжийг нээж байна. Цаашид засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогоо үргэлжлүүлэх замаар авто замын сүлжээг өргөтгөх юм.

Төмөр зам бараг бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна: Төмөр зам нь ачаа тээвэрлэх хүчин чадлаа бараг 100 хувь ашиглаж байна. Тодруулбал, 2014 онд 20.9 сая тн ачаа тээвэрлэсэн нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна гэсэн үг. Мөн Монголын босоо тэнхлэгийг огтолсон дан шугамтай төмөр замын сүлжээгээр хөдөө орон нутагт ачаа тээвэрлэн хүргэх боломж хязгаарлагдмал юм. Ийм нөхцөлд авто замын тээвэрлэлт зайлшгүй шаардлагатай болно.

Замын-Үүдийн чөлөөт бүсийн давуу тал: "Монгол Шуудан" ТӨХК нь логистикийн төвийг Замын-Үүдийн чөлөөт бүсэд барих бөгөөд "Чөлөөт бүсийн хууль"-ийн дагуу үл хөдлөх хөрөнгийн татвар, гаалийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, газар ашигласны хураамжаас чөлөөлөгдөх, хөнгөлөлт эдлэх олон талын эдийн засгийн давуу талуудтай. Иймээс өрсөлдөгчидтэй үнээр өрсөлдөх боломж нэмэгдэнэ.

Хөрөнгө оруулалтын хэмжээ: Нэмэлт хувьцаа гаргаснаар татан төвлөрүүлэх хөрөнгө нь уг "авто замын логистикийн үйлчилгээ"-ний төслийг амжилттай эхлүүлж олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг бий болгох, цаашид сүлжээгээ өргөтгөх боломжийг нээх юм.

Нийгэмд үзүүлэх эерэг нөлөө, компанийн хөгжлийг шинэ түвшинд гаргаж буй байдал, дэд бүтцийн таатай нөхцөл, байршлийн давуу тал, үйлчилгээний давуу тал зэрэг нь уг төсөл амжилттай хэрэгжих үндэслэл болох юм.

## ТӨСЛИЙН ДАВУУ ТАЛ– ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ҮР ДҮН

## Давуу тал

- Гаалийн хяналт: Логистикийн төвийг Замын Үүдийн чөлөөт бүсэд байгуулах бөгөөд гааль, орлогын албан татварын хөнгөлөлтүүд эдлэх учраас зардал бага гарна. Мөн цаг хугацаа хэмнэх боломжтой. Үүний хэрээр үйлчилгээний эрэлт өснө
- Тээвэрлэлтийн явц тодорхой: Харилцагчид бараагаа хаана явж байгааг болон хэзээ өөрт нь ирэхийг интернетээр хянах боломжтой болсноор өөрийн ажлыг төлөвлөх, цаг хугацаа хэмнэнэ. Үүний хэрээр компанид итгэх итгэл нэмэгдэнэ.
- Зориулалтын тээвэрлэлт: Стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгсэл ашиглах учир харилцагчийн бараа, бүтээгдэхүүнд чанарын өөрчлөлт орохгүй. Үүний хэрээр компанид итгэх итгэл нэмэгдэнэ. Үйлчилгээний эрэлт өснө.
- Нэгдсэн тээврийн сүлжээтэй: Харилцагчийн барааг Улаанбаатарын зөвхөн нэг цэгт хүргээд зогсохгүй, шуудангийн сүлжээгээ ашиглан гарт нь хүргэх боломжтой. Үүний хэрээр үйлчилгээний эрэлт өснө.
- Даатгалтай: Нэгдсэн байдлаар даатгуулах учир хямд зардлаар иж бүрэн даатгал хийгдэх боломжтой. Ингэснээр харилцагчид бараа бүтээгдэхүүндээ санаа зовох зүйлгүй болно. Үүний хэрээр компанид итгэх итгэл нэмэгдэнэ.
- Үнэ хямд: 1тн ачааг 200 төгрөгөөр тээвэрлэх боломжтой. Өрсөлдөгчийн дундаж үнэ 200 төгрөгөөс их. Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас үзнэ үү.

## ӨРСӨЛДӨГЧДИЙН СУЛ ТАЛ– ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

## Сул тал

- Гаалийн хяналт: Гаалийн хяналтын шат дамжлага олон, тодорхой бус байдал их, цаг хугацаа алддаг, өөрсдөө бүх процесст оролцдог
- Тээвэрлэлтийн явц тодорхойгүй: Тээвэрлэлтийн замналыг харах, бараагаа хэзээ хүлээн авах нь тодорхой бус
- Зориулалтын бус тээвэрлэлт: Бараа, бүтээгдэхүүний чанарыг алдагдуулахгүйгээр тээвэрлэх зориулалтын машин цөөхөн
- Нэгдсэн тээврийн сүлжээгүй: Замын-Үүдээс Улаанбаатарт барааг авчирсан ч Улаанбаатарт хүссэн газраа хүргүүлэх боломжгүй эсвэл хөдөө орон нутагруу тээвэрлэхэд дахин асуудал үүсдэг.
- Даатгалгүй: Хулгай, гэнэтийн осол, гал түймэр, ус үерийн үед хохирох эрсдэлтэй.
- Тээвэрлэлт болон хадгалалтын үеэр тогтмол хянах шаардлага үүсдэг: Харилцагч өөрийн ачаанд тогтмол хяналт тавихгүй бол эрсдэл хүлээх магадлалтай.
- Харилцагч өөрөө ачаагаа авдаг: Харилцагчийн ачааг гарт нь хүргэж өгдөггүй.

# "МОНГОЛ ШУУДАН" ТӨХК ЗАХ ЗЭЭЛД ХЭРХЭН НЭВТРЭХ ВЭ?

Авто замын логистикийн үйлчилгээ үзүүлэх учраас тухайн чиглэл дэх зах зээл ямар хэмжээнд байгаа болон тухайн чиглэлийн авто замын чанар ямар түвшинд байгааг харгалзан үзэх хэрэгтэй.




**1-р ээлж** - Замын-Үүд-Улаанбаатар – 2017 он, Улаанбаатар-Алтан булаг – 2019 он
**2-р ээлж** - Улаанбаатар-Дархан-Эрдэнэт-Хөвсгөл – 2018 он
**3-р ээлж** - Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад – 2018 он
**4-р ээлж** - Улаанбаатар-Баянхонгор – 2019 он
**5-р ээлж** – Улаанбаатар –Өндөрхаан – Баруун-Урт, Чойбалсан – 2019 он

## ЗАМЫН ҮҮД ДЭХ ЛОГИСТИКИЙН ТӨВ

Байгууламжийн байрлал: Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Замын-үүд чөлөөт бүсэд
Байгууламжийн хэмжээ: Нийт 3300 м², 2 давхар барилга
Байгууламжийн зохион байгуулалт:
I давхар:

- 1-р блок - Шуудан солилцох, ялган боловсруулах хэсгийн ажлын байр
- 2-р блок - Уулзалтын танхим, хооллох танхим, оффисын өрөө, цахилгаан, дулааны өрөө, ажилчдын амралтын өрөө, хамгаалалтын алба
- 3-р блок - Агуулах
- 4-р блок – Автомашины гараж болон засвар үйлчилгээний ажлын байр
- 5-р блок - Ногоон байгууламж, автомашины зогсоол, харуулын байр

II давхар:

- Оффисын өрөө, Серверийн өрөө, IT өрөө, хяналтын өрөө, Хурлын өрөө, Амралтын өрөө

Өнөөгийн нөхцөл байдал: Чөлөөт бүсэд газар эзэмших тендерт компани оролцож 3.5 га газар эзэмших эрхээ авсан. Кадастрын зурагт оруулж байна.

Уг төвийн хяналтын өрөөнд шуудангийн үйл ажиллагаанд хэрэглэгддэг бүх системүүдийг нэгтгэн байрлуулах бөгөөд 24 цагийн турш хянан ажиллах болно.



## ТӨЛӨВЛӨЖ БУЙ БАРИЛГЫН УРЬДЧИЛСАН ЕРӨНХИЙ ЗУРАГ

План зураг



1 ба 2-р блокийн харагдах байдал





1-р блокийн 3D зураг



2-р блокийн 3D зураг



## УБ ХОТЫН ГААЛИЙН БАТАЛГААТ АГУУЛАХ, ЯЛГАН БОЛОВСРУУЛАХ ТӨВ

**Байгууламжийн байрлал:** Яармаг, Монгол Шуудан ТӨХК- ийн 30-р салбар

**Байгууламжийн хэмжээ:** Нийт 1875 м², нийт 3 давхар барилга

Байгууламжийн зохион байгуулалт:

**Гаражийн давхар:** Шуудан солилцох хэсэг (гаалийн баталгаат бүс буюу гаалийн баталгаат агуулах, гаалийн болон мэргэжлийн хяналтын байцаагчийн өрөө)

I давхар: Шуудан ялган боловсруулах хэсэг

II давхар: Оффис, гаалийн оффис, серверийн өрөө, хяналтын өрөө, IT өрөө, хурлын өрөө,

Өнөөгийн нөхцөл байдал: Компанийн 30-р салбарт шуудангийн үйлчилгээ эрхэлж байгаа бөгөөд тоосгон нэг давхар байшинд үйл ажиллагаа явуулдаг.






Одоогийн байдал




Төсөл хэрэгжсэний дараа

Яармагийн 3-р буудлын баруун талд замын хойд талдаа Хан-Уул дүүргийн цагдаагийн II хэлтсийн ард.

Гэрчилгээн дээрх нийт газрын талбайн хэмжээ: 1,148м2.

Шуудангийн 30-р салбарын барилгын хэмжээ: 13м*13м

## ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ХУРААНГУЙ

Сая төгрөг

| Хугацаа | 2015.12-2016.03 | 2016.03-2016.09 | 2016.09-2017.01 | Нийлбэр дүн |
|---|---|---|---|---|
| Зарцуулалт | Барилгын ажил эхлүүлэх үйл ажиллагаа | Барилгын ажил үргэлжлүүлэх үйл ажиллагаа | Барилга, байгууламжийг ашиглалтанд оруулах | |
| Барилга | | 4,100.00 | | 4,100.00 |
| Машин механизм | | | 1,800.00 | 1,800.00 |
| Тоног төхөөрөмж | | | 178.00 | 178.00 |
| Тавилга эд хогшил | | | 20.00 | 20.00 |
| Нийлбэр дүн | - | 4,100.00 | 1,998.00 | 6,098.00 |

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖИЙН ТААМАГЛАЛ

| Ашигт ажиллагааны харьцаа | 2015T | 2016T | 2017T | 2018T | 2019T | 2020T | 2021T | 2022T | 2023T | 2024T | 2025T |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Цэвэр ахиуц ашиг | -0.99% | 4.72% | 6.95% | 9.10% | 11.45% | 13.41% | 14.00% | 13.54% | 13.11% | 12.71% | 12.35% |
| Нийт ахиуц ашиг | 17.91% | 17.91% | 26.85% | 30.45% | 34.01% | 36.88% | 37.23% | 35.63% | 34.15% | 32.80% | 31.56% |
| Үйл ажиллагааны ахиуц ашиг | -1.10% | 5.24% | 7.73% | 10.11% | 12.73% | 14.90% | 15.56% | 15.04% | 14.56% | 14.13% | 13.73% |
| Татварын өмнөх ахиуц ашиг | -1.10% | 5.24% | 7.73% | 10.11% | 12.73% | 14.90% | 15.56% | 15.04% | 14.56% | 14.13% | 13.73% |
| Хөрөнгийн өгөөж | -0.49% | 2.58% | 4.15% | 5.56% | 7.10% | 8.32% | 8.66% | 8.36% | 8.11% | 7.90% | 7.72% |
| Хөрөнгийн үйл ажиллагааны өгөөж | -0.55% | 2.87% | 4.62% | 6.18% | 7.89% | 9.25% | 9.62% | 9.29% | 9.01% | 8.78% | 8.58% |
| Эздийн өмчийн өгөөж | -0.56% | 2.87% | 4.73% | 6.42% | 8.25% | 9.71% | 10.12% | 9.76% | 9.45% | 9.20% | 8.98% |

| Du Pont шинжилгээ | 2015T | 2016T | 2017T | 2018T | 2019T | 2020T | 2021T | 2022T | 2023T | 2024T | 2025T |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Татварын нөлөө | 90.00% | 90.00% | 90.00% | 90.00% | 90.00% | 90.00% | 90.00% | 90.00% | 90.00% | 90.00% | 90.00% |
| Зээлийн хүүгийн нөлөө | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| Үйл ажиллагааны ахиуц ашиг | -1.10% | 5.24% | 7.73% | 10.11% | 12.73% | 14.90% | 15.56% | 15.04% | 14.56% | 14.13% | 13.73% |
| Хөрөнгийн эргэц | 0.50 | 0.55 | 0.60 | 0.61 | 0.62 | 0.62 | 0.62 | 0.62 | 0.62 | 0.62 | 0.62 |
| Санхүүгийн хөшүүрэг | 1.12 | 1.11 | 1.14 | 1.15 | 1.16 | 1.17 | 1.17 | 1.17 | 1.17 | 1.16 | 1.16 |
| Эздийн өмчийн өгөөж | -0.56% | 2.87% | 4.73% | 6.42% | 8.25% | 9.71% | 10.12% | 9.76% | 9.45% | 9.20% | 8.98% |

| ХУГАЦАА | 2015T | 2016T | 2017T | 2018T | 2019T | 2020T | 2021T | 2022T | 2023T | 2024T | 2025T | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дансны үнэ | 201.78 | 207.07 | 216.07 | 228.93 | 246.58 | 269.12 | 294.79 | 321.86 | 350.46 | 380.71 | 412.78 | ХАРЬЦУУЛАХ ЖИШИГ |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг | (0.95) | 5.88 | 10.00 | 14.28 | 19.61 | 25.04 | 28.53 | 30.08 | 31.77 | 33.62 | 35.68 | |
| Хувьцааны үнэ | 185.00 | 185.00 | 185.00 | 185.00 | 185.00 | 185.00 | 185.00 | 185.00 | 185.00 | 185.00 | 185.00 | |
| P/B | 0.92 | 0.89 | 0.86 | 0.81 | 0.75 | 0.69 | 0.63 | 0.57 | 0.53 | 0.49 | 0.45 | |
| P/E | (194.69) | 31.49 | 18.49 | 12.95 | 9.43 | 7.39 | 6.48 | 6.15 | 5.82 | 5.50 | 5.19 | |
| P/B - жишиг | 1.00 | 1.10 | 1.20 | 1.30 | 1.30 | 1.40 | 1.50 | 1.60 | 1.70 | 1.80 | 1.90 | P/B= 1-2 |
| P/B-д үндэслэсэн ханш | 201.78 | 227.78 | 259.29 | 297.61 | 320.55 | 376.76 | 442.19 | 514.98 | 595.78 | 685.28 | 784.28 | |
| P/E - жишиг | 13.00 | 14.00 | 15.00 | 17.00 | 18.00 | 19.00 | 20.00 | 20.00 | 20.00 | 20.00 | 20.00 | P/E= 10-20 |
| P/E-д үндэслэсэн ханш | | | | 242.84 | 352.96 | 475.79 | 570.57 | 601.59 | 635.43 | 672.35 | 712.62 | |
| Таамагласан дундаж ханш | 201.78 | 227.78 | 259.29 | 270.23 | 336.76 | 426.28 | 506.38 | 558.29 | 615.61 | 678.82 | 748.45 | |
| Өгөөж | 9.07% | 23.12% | 40.16% | 46.07% | 82.03% | 130.42% | 173.72% | 201.78% | 232.76% | 266.93% | 304.57% | |

сая.төгрөг

| БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО | 2016Т | 2017Т | 2018Т | 2019Т | 2020Т | 2021Т | 2022Т | 2023Т | 2024Т | 2025Т |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Замын-Үүдээс УБ-т чиглэсэн ачаа | | 1,235.52 | 2,059.20 | 2,882.88 | 3,706.56 | 4,118.40 | 4,118.40 | 4,118.40 | 4,118.40 | 4,118.40 |
| Хятадаас МУ-д тараагдах и-худалдааны бараа | | 216.00 | 360.00 | 504.00 | 648.00 | 720.00 | 720.00 | 720.00 | 720.00 | 720.00 |
| Улаанбаатараас хөдөө орон нутагт | | 598.60 | 823.68 | 1,153.15 | 1,482.62 | 1,647.36 | 1,647.36 | 1,647.36 | 1,647.36 | 1,647.36 |
| Дотоодод тараагдах и-худалдааны бараа | | 7.20 | 12.00 | 16.80 | 21.60 | 24.00 | 24.00 | 24.00 | 24.00 | 24.00 |
| **НИЙТ БОРЛУУЛАЛТ** | | 2,057.32 | 3,254.88 | 4,556.83 | 5,858.78 | 6,509.76 | 6,509.76 | 6,509.76 | 6,509.76 | 6,509.76 |
| Үндсэн ба нэмэгдэл цалин | | 373.20 | 622.00 | 870.80 | 1,119.60 | 1,244.00 | 1,244.00 | 1,244.00 | 1,244.00 | 1,244.00 |
| НДШ/ЭМД | | 37.32 | 62.20 | 87.08 | 111.96 | 124.40 | 124.40 | 124.40 | 124.40 | 124.40 |
| Томилолт | | 30.00 | 50.00 | 70.00 | 90.00 | 100.00 | 100.00 | 100.00 | 100.00 | 100.00 |
| Уур ус халаалт | | 197.99 | 329.98 | 461.97 | 593.96 | 659.96 | 659.96 | 659.96 | 659.96 | 659.96 |
| Гэрэл цахилгаан | | 19.50 | 32.50 | 45.50 | 58.50 | 65.00 | 65.00 | 65.00 | 65.00 | 65.00 |
| Шуудан холбооны зардал | | 3.00 | 5.00 | 7.00 | 9.00 | 10.00 | 10.00 | 10.00 | 10.00 | 10.00 |
| Үндсэн ба туслах материал | | 45.00 | 75.00 | 105.00 | 135.00 | 150.00 | 150.00 | 150.00 | 150.00 | 150.00 |
| Элэгдлийн зардал | | 482.00 | 482.00 | 482.00 | 482.00 | 482.00 | 482.00 | 482.00 | 482.00 | 482.00 |
| Хөдөлмөр хамгаалалт ариун цэвэр | | 15.00 | 25.00 | 35.00 | 45.00 | 50.00 | 50.00 | 50.00 | 50.00 | 50.00 |
| Бичиг хэрэг хангамжийн зардал | | 30.00 | 50.00 | 70.00 | 90.00 | 100.00 | 100.00 | 100.00 | 100.00 | 100.00 |
| Шатахуун | | 366.60 | 611.00 | 855.40 | 1,099.80 | 1,222.00 | 1,222.00 | 1,222.00 | 1,222.00 | 1,222.00 |
| Сэлбэг | | 90.00 | 150.00 | 210.00 | 270.00 | 300.00 | 300.00 | 300.00 | 300.00 | 300.00 |
| Харуул хамгаалалт, гал команд | | 6.00 | 10.00 | 14.00 | 18.00 | 20.00 | 20.00 | 20.00 | 20.00 | 20.00 |
| Зар сурталчилгаа | | 30.00 | 50.00 | 70.00 | 90.00 | 100.00 | 100.00 | 100.00 | 100.00 | 100.00 |
| Сургалт | | 18.00 | 30.00 | 42.00 | 54.00 | 60.00 | 60.00 | 60.00 | 60.00 | 60.00 |
| Авто машин, замын хураамж | | 6.00 | 10.00 | 14.00 | 18.00 | 20.00 | 20.00 | 20.00 | 20.00 | 20.00 |
| Хөрөнгийн даатгал | | 20.00 | 20.00 | 20.00 | 20.00 | 20.00 | 20.00 | 20.00 | 20.00 | 20.00 |
| Үл хөдлөх хөрөнгийн татвар | | 15.00 | 15.00 | 15.00 | 15.00 | 15.00 | 15.00 | 15.00 | 15.00 | 15.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | | 1,784.61 | 2,629.68 | 3,474.75 | 4,319.82 | 4,742.36 | 4,742.36 | 4,742.36 | 4,742.36 | 4,742.36 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ** | | 272.71 | 625.20 | 1,082.08 | 1,538.96 | 1,767.40 | 1,767.40 | 1,767.40 | 1,767.40 | 1,767.40 |
| Зээлийн хүү | | - | - | - | - | - | - | - | - | - |
| Татвар төлөхийн өмөх ашиг | | 168.32 | 625.20 | 1,082.08 | 1,538.96 | 1,767.40 | 1,767.40 | 1,767.40 | 1,767.40 | 1,767.40 |
| Татварын зардал | | - | 62.52 | 108.21 | 153.90 | 176.74 | 176.74 | 176.74 | 176.74 | 176.74 |
| **ЦЭВЭР АШИГ** | | 168.32 | 562.68 | 973.87 | 1,385.07 | 1,590.66 | 1,590.66 | 1,590.66 | 1,590.66 | 1,590.66 |
| Цэвэр ахиуц ашиг | | 8.62% | 17.29% | 21.37% | 23.64% | 24.44% | 24.44% | 24.44% | 24.44% | 24.44% |

# САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТААМАГЛАЛ

**Компани авто замын логистикийн үйлчилгээний төслийг хэрэгжүүлснээр санхүүгийн чадавхиа нэмэгдүүлнэ.**




Компани өнөөгийн бэлэн мөнгөний нөөцөөрөө цаашид хэдэн хоногийн турш ажиллах боломжтойг илэрхийлдэг "тогтвортой байдлын интервал" нь 2015 онд огцом өсч 426 хоног болж байгаа нь нэмэлт хувьцаа гаргаж хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэхтэй холбоотой юм. Харин 2016 оноос хойш 2025 он хүртэл 255 хоногоос 454 хоног өссөн нь шинээр хэрэгжүүлэх төсөл болон шуудангийн үйлчилгээний орлогын өсөлттэй холбоотой.




Эргэлтийн бус хөрөнгийн эргэцийн өсөлт нь ирэх 10 жилийн хугацаанд нэмж эргэлтийн бус хөрөнгө худалдан авах их дүн байхгүйтэй холбоотой юм. Харин нийт хөрөнгийн эргэц тогтвортой байгаа нь эргэлтийн хөрөнгийн хэмжээ бизнесийн үйл ажиллагаа өргөжихийн хэрээр нэмэгдэж байгаатай холбоотой юм.




Нэмж гаргасан хувьцаанаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлтөөс үүдэн хөрвөх чадварын харьцаа 2.76-аас 6.84 нэгжид хүрч өсөх юм. Харин төсөл амжилттай хэрэгжиснээр эргэлтийн харьцаа 2016 оноос 2025 он хүртэл 3.52-оос 6.24 нэгжид хүрч өсөх юм. Ингэснээр хөрвөх чадвар улам нэмэгдэнэ




Төлбөрийн чадварын харьцаа 9.07%-иас 14.39% хувь хүртэл өсч байгаа нь богино хугацаат өр төлбөрийн хэмжээ бизнесийн үйл ажиллагаа өргөжихийн хэрээр нэмэгдэж байгаатай холбоотой юм. Компани нь хүү төлдөг богино хугацаат эсвэл урт хугацаат зээл ашиглахгүй байгаа нь төлбөрийн чадварыг өндөр түвшинд хадгалахад чухал нөлөө үзүүлж байна.




Нийт ахиуц ашгийн хэмжээ 2015 оноос 2020 хүртэл 17.91%-иас 36.88% хувь хүртэл өсч байгаа нь авто замын логистикийн үйлчилгээний төслийн өсөлттэй холбоотой юм. Харин эргээд 2025 он хүртэл 31.56% хүртэл буурч байгаа нь төслийн хүчин чадал бүрэн хэмжээнд хүрч орлогын өсөлт саарахтай холбоотой. Үүнийг дагаад үйл ажиллагааны ахиуц ашиг, цэвэр ахиуц ашиг 2020 он гэхэд харгалзан 14.9%, 13.41%-д хүрэх бол 2025 онд 13.73%, 12.35%-д хүрэх төлөвтэй байна




Хөрөнгийн өгөөжийн хэмжээ 2015 оноос 2020 гэхэд 8.32%-д хүрэх төлөвтэй байгаа бол 2025 онд 7.72%-д хүрэх төлөвтэй байна. Харин эздийн өмчийн хувьд 2020 онд 9.71%-д хүрэх бол 2025 онд 8.98%-д хүрэхээр байна.
2015 онд компани алдагдалтай ажиллах төлөвтэй байгаа бол 2016 оноос ашигтай ажиллаж эхэлнэ гэж тооцоолсон болно.

## ИРЭХ 3-5 ЖИЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Ирэх жилүүдэд эдийн засгийн өсөлтийг тэжээх голлох хүчин зүйл нь гадаадын шууд хөрөнгө оруулалт байх төлөвтэй байна. Учир нь Хятадын эдийн засгийн өсөлтийн бууралттай холбоотойгоор түүхий эдийн үнэ ирэх 2-3 жилийн хугацаанд төдийлөн сэргэх төлөвгүй байна. Иймээс экспортын орлого өсөн нэмэгдэх боломж хязгаарлагдмал байгаа бол гадаад өр дээд хэмжээндээ хүрсэн учир бонд гаргаж санхүүжилт татах боломж мөн адил хязгаарлагдмал байна. Тэгвэл гадаадын шууд хөрөнгө оруулалт хэрхэн өсөх боломжтойг дараах хэсэгт оруулав.




## ОЮУ ТОЛГОЙН ДАЛД УУРХАЙН САНХҮҮЖИЛТ ШИЙДЭГДЭВ

Хоёр жил орчмын хугацаанд Рио Тинто болон МУ-ын Засгийн газрын хооронд үргэлжилсэн Оюу толгойн маргаан эцэслэгдэж далд уурхайг хөгжүүлэх төлөвлөгөөг талууд баталлаа. Санхүүжилтийг арван хоёрдугаар сарын дундуур батлаж ирэх оны дунд үеэс бодит бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу ирэх долоон жилийн хугацаанд 6.2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэх ба үүний 4.7 тэрбум нь далд уурхайд, 1.5 тэрбум нь урсгал зардалд зарцуулагдах юм.

| In USD billions | Year 1 | Year 2 | Year 3 | Year 4 | Year 5 | Year 6 | Year 7 | Total |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Capital** | | | | | | | | |
| Underground Development capital | 0.3 | 1.1 | 1.0 | 1.1 | 0.7 | 0.5 | 0.1 | 4.7 |
| Sustaining capital | 0.1 | 0.1 | 0.0 | 0.1 | 0.4 | 0.4 | 0.5 | 1.5 |
| VAT and Duties on capital | 0.0 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.6 |
| **Total Capital** | **0.4** | **1.2** | **1.1** | **1.3** | **1.2** | **1.0** | **0.4** | **6.8** |
| **Estimated Direct Mongolian Spend** | | | | | | | | |
| Domestic operating cost expenditure | 0.6 | 0.6 | 0.6 | 0.6 | 0.6 | 0.6 | 0.7 | 4.3 |
| Domestic capital cost expenditure | 0.2 | 0.5 | 0.4 | 0.4 | 0.4 | 0.4 | 0.2 | 2.5 |
| Direct payment to Government of Mongolia | 0.3 | 0.3 | 0.3 | 0.3 | 0.3 | 0.3 | 0.4 | 2.2 |
| **Total Estimated Direct Mongolian Spend** | **1.1** | **1.3** | **1.2** | **1.3** | **1.4** | **1.3** | **1.3** | **9.0** |

## ОЮУ ТОЛГОЙГООС БУСАД ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ НЭМЭГДЭХ БОЛОМЖ

-106 лицензийг эргэн эргэлтэнд оруулахын зэрэгцээ хайгуулын зөвшөөрөл олгож эхэллээ
2015 оны аравдугаар сарын байдлаар нийт 50 талбайд сонгон шалгаруулалтыг зарлан явуулснаас 42 талбайд шинээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон. 106 лиценз эргэлтэнд орсноор тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг гаднаас татах юм.

-2015 оноос хайгуулын тусгай зөвшөөрөл олгож эхлэв. Дөрвөн жил хагасын хугацаанд зогсоод байсан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг энэ оноос эхлүүллээ. Ес дүгээр сарын байдлаар энэ онд 538 тусгай зөвшөөрөл шинээр олгосон ба аймгийн Засаг даргаас санал авахаар бэлтгэж байгаа 562 өргөдөл байна. Монгол Улсын нутаг дэвсгэрийн 19.8 хувь буюу 31 сая га талбайд тусгай зөвшөөрөл олгохоор төлөвлөсөн нь хайгуулын лиценз олгогдсон 7.5%-тай харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Хайгуулын лиценз олгогдож эхэлснээр ирэх 3-5 жилийн хугацаанд хайгуул хийх, ашиглалт хийх зорилгоор гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гэж үзэж байна.

-Бусад салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэх боломж бүрдэж байна. Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар "нийт 20 гаруй төслийн хөрөнгө оруулалтыг шийдсэн. Дийлэнхи нь концессын гэрээгээр хийгдэнэ. 2014 оны сүүлчээс өнөөг хүртэл 17 гэрээнд гарын үсэг зурсан. 5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт 3-4 жилд орж ирэх юм" гэжээ.

-Монгол ба Хятадын эдийн засгийн стратегийн түншлэл бодит амьдралд хэрэгжиж эхэллээ. Монгол-Хятадын анхдугаар экспо зохион байгуулагдаж цаашид хоёр жил тутамд зохион байгуулагдахаар боллоо. Уг экспоны үеэр 100 гаруй баримт бичиг байгуулагдаж 90 тэрбум юаны гэрээ хийгдсэн. "Торгоны зам" төслийг эрчимжүүлэхэд 13 төсөл, банк санхүүгийн 8, аялал жуулчлалын 10 төсөлд гарын үсэг зурсан. Мөн "Хятад-Монголын хамтарсан аж үйлдвэрийн парк" байгуулах санамж бичиг байгууллаа. Энэхүү хамтын ажиллагаа нь урт хугацаанд Монголын экспортыг өсгөх, Хятадаас Монголд хийгдэх хөрөнгө оруулалт нэмэгдэх боломжийг нээн өгөх юм.

## ИРЭХ ЖИЛҮҮДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ТААМАГЛАЛ




Эх сурвалж: ДБ, АХБ, ОУВС, МБ, СЯ

Дэлхийн банкнаас 2016 онд эдийн засгийн өсөлт хамгийн бага түвшинд хүрнэ гэж таамаглаж байгаа бол Азийн Хөгжлийн банк, ОУВС, Монгол банк, Сангийн яамнаас 2015 онд хамгийн бага түвшинд хүрнэ гэж таамаглажээ. Хэдийгээр өсөлтийн хамгийн доод түвшин 2015 эсвэл 2016 онд тохионо гэж таамагласан ч ирэх 3-5 жилийн хугацаанд эдийн засгийн өсөлт нэмэгдэнэ гэдэгт бүгд ижил байр суурьтай байгаа юм. Энэ нь 2016 оны дунд үед эхлэх Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалттай голчлон холбоотой. Үүний зэрэгцээ Таван толгойн төсөл хэрэгжвэл эдийн засгийн өсөлт огцом нэмэгдэх боломжтой гэдгийг дурьдах нь зүйтэй.

Монголын эдийн засгийн өсөлтийн таамаглал




Дэлхийн банкны хувьд 2016 онд эдийн засгийн өсөлт 0.8%-д хүрнэ гэж таамаглаж байгаа бол 2020 он гэхэд 11%-д хүрч өснө гэж таамаглажээ.

Нэгтгэн дүгнэвэл, ирэх 3-5 жилийн хугацаанд макро эдийн засгийн орчин сайжирч хөрөнгийн зах зээлд эерэг нөлөө үзүүлэх төлөвтэй байна.

## МОНГОЛ ШУУДАН КОМПАНИЙН ОРЛОГО БА ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ ХООРОНДЫН ХАМААРАЛ

Үндэсний Статистикийн Хорооны "Шуудангийн үйлчилгээний үзүүлэлт"-эд бичиг, захидал, боодол, тогтмол хэвлэл, цахилгаан мэдээ, утасны яриа гэсэн статистик тоо баримтууд байдаг. Үүнээс Монгол Шуудан компанийн үйлчилгээнд бичиг, захидал, боодол, тогтмол хэвлэл багтдаг. Дээрх үйлчилгээ болон нэрлэсэн ДНБ, компанийн орлогын хоорондын хамаарлыг 2007-2014 оны өгөгдөлд тулгуурлан корреляцийн шинжилгээгээр тодорхойлоход:

| | Нэрлэсэн ДНБ | Бичиг, захидал, боодол | Тогтмол хэвлэл | Борлуулалтын орлого |
|---|---|---|---|---|
| Нэрлэсэн ДНБ | 1 | | | |
| Бичиг, захидал, боодол | 0.848138154 | 1 | | |
| Тогтмол хэвлэл | -0.417930424 | -0.540282825 | 1 | |
| Борлуулалтын орлого | 0.972452569 | 0.888817751 | -0.512996066 | 1 |

Дээрх хүснэгтээс харахад, борлуулалтын орлого нь нэрлэсэн ДНБ болон бичиг, захидал, боодолтой нягт эерэг хамааралтай байна.

Энэхүү хамааралд тулгуурлан мэдрэмжийн шинжилгээг нэрлэсэн ДНБ ба борлуулалтын орлого, мөн бичиг захидал боодол ба борлуулалтын орлогын хооронд тооцоход:

| Мэдрэмж | |
|---|---|
| Компанийн борлуулалт ба бичиг захидал боодол | Компанийн борлуулалт ба ДНБ |
| 2.33% | 0.49% |

Бичиг, захидал боодлын хэмжээ 1 хувиар өсөхөд компанийн борлуулалтын орлого 2.33% өсдөг бол нэрлэсэн ДНБ 1 хувиар өсөхөд компанийн борлуулалтын орлого 0.49% өсдөг байна. Мөн энгийн регрессийн шинжилгээ хийж үзэхэд бичиг захидал боодол ба нэрлэсэн ДНБ нь компанийн борлуулалтын орлогыг тайлбарлагч хүчин зүйл мөн болох нь батлагдсан. Дэлгэрэнгүйг хавсралт 11-ээс үзнэ үү.

### Дотоодын шуудангийн зах зээл







### Зах зээлд эзлэх хувь




Монгол Шуудан компани нь үндсэн сүлжээ эзэмшигч буюу улс даяар шуудангийн үйлчилгээ үзүүлдэг, төрийн дэмжлэгтэй, хямд үнэтэй байгаа нь дотоодын зах зээлд өрсөлдөх чадварыг бий болгож байна. Харин улс хоорондын шуудангийн зах зээлд нөхцөл байдал өөр байгаа

### Улсын хоорондын шуудангийн зах зээл




Улс хоорондын орох гарах урсгал сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа бөгөөд уг зах зээлд шинээр өрсөлдөгчид нэвтэрч байна. Өрсөлдөгчдийн гол давуу тал нь хурдан шуурхай үйлчилж байгаад оршдог. Харин "Монгол Шуудан" ТӨХК-ийн хувьд гаалийн хяналт өндөр, татвар төлөлт өндөр, ялган боловсруулах төв нь хотын төвд байрладаг учраас цаг хугацаа алддаг гэх зэрэг шалтгаанаар хэрэглэгчдээ алдахад хүрч байна.

### Зах зээлд эзлэх хувь



"Монгол Шуудан" ТӨХК нь ирэх 3-5 жилийн хугацаанд дараах байдлаар зах зээлээ тэлэх төлөвлөгөөтэй байна:

| Үйлчилгээ | И-худалдааны хүргэлт | Улс хоорондын карго | Дотоодын дайвар | Одоогийн үйлчилгээгээ өргөжүүлэх |
|---|---|---|---|---|
| Зах зээлийн хамрах хүрээ | Дотоод ба гадаадын и-худалдаа | Улс хоорондын орох ба гарах | Улаанбаатар хөдөө орон нутаг | Бичиг баримтын хүргэлт |
| Зах зээлийн хэмжээ | 1 тэрбум төгрөг | 13.79 тэрбум төгрөг | 321 сая төгрөг | 12.5 тэрбум төгрөг |
| Хугацаа | 2014 | 2014 | 2014 | 2016 |
| Эх сурвалж | -И-худалдааны анхдугаар конференц<br>-Харилцаа Холбооны Зохицуулах Хороо<br>-Имаркетер<br>-Дотоодод и-худалдаа эрхэлдэг 25 компаниас авсан судалгаа | -Гаалийн ерөнхий газар<br>-Карго ачаа тээвэрлэлт хийдэг 24 компаниас авсан судалгаа | -Драгон ба Баянзүрх товчооны 20 жолоочоос авсан судалгаа | -Компанийн 2016 оны бизнес төлөвлөгөө |
| Тооцоолол | Судалгаанд үндэслэн хамгийн гутранги байдлаар тооцоолсон. | Судалгаанд үндэслэн хамгийн гутранги байдлаар тооцоолсон. | Судалгаанд үндэслэн хамгийн гутранги байдлаар тооцоолсон. | "Монгол Шуудан" ТӨХК-ийн ТУЗ-аас баталсан |

Дээрх хүргэлтийн үйлчилгээг үзүүлэхийн тулд тээвэрлэлт хийх өөрийн сүлжээтэй байх шаардлага үүсч байна. Гэвч зөвхөн шуудан хүргэх зорилгоор тээвэрлэлтээ нэмэгдүүлэх нь эдийн засгийн үр ашиг муутай

**АВТО ЗАМЫН ЛОГИСТИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**
Зах зээлийн багтаамж: 37.48 тэрбум төгрөг -2014 он
Ачааны төрөл: Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, хувцас
Чиглэл: Замын-Үүд-Улаанбаатар, Улаанбаатар-Хөдөө орон нутаг

# ЭРСДЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Энэхүү хэсэгт эрсдэлийн хүчин зүйлсийг үүсч буй орчиноос нь гадаад ба дотоод гэж ангиллаа. Ангилалын дагуу компанид учирч болох голлох эрсдэлүүд болон тэдгээрээс хэрхэн зайлсхийх боломжийг тодорхойлсон.

| Эрсдэл үүсч буй орчин | Эрсдэлийн төрөл | Компанид хэрхэн нөлөөлөх вэ? | Тайлбар | Зайлсхийх арга зам | Эрсдэлээс зайлсхийхэд шаардагдах үйл ажиллагаа гүйцэтгэгч |
|---|---|---|---|---|---|
| Гадаад | Макро эдийн засаг | Орлогод аажмаар нөлөөлөх | Макро эдийн засгийн сөрөг нөлөөгөөр компанийн орлого буурах | Макро эдийн засгийн орчныг хагас жил тутамд тодорхойлдог байх | Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс нь өөрсдөө судалгаа хийх эсвэл томоохон судалгааны байгууллагуудын судалгааг тогтмол ашиглах |
| Гадаад | Хууль эрх зүйн орчин | Орлогод огцом нөлөөлөх | Хууль эрх зүйн орчны өөрчлөлттэй холбоотойгоор компанийн орлого буурах | Мэдээлэл Технологи Шуудан Харилцаа Холбооны газар, Харилцаа Холбооны Зохицуулах газартай нягтхамтран ажиллах | Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс нь зохицуулагч байгууллагуудтай тогтмол хамтран ажиллаж, хууль эрх зүйн орчны өөрчлөлт өөрсдийн саналыг оруулах |
| Гадаад | Техник, технологи | Орлогод аажмаар нөлөөлөх | Технологийн өөрчлөлттэй холбоотойгоор компанийн орлого буурах | Шуудангийн технологитой холбоотой судалгааг жилд нэг удаа хийдэг байх | Мэдээллийн технологийн хэлтэс нь тогтмол судалгаа хийх |
| Гадаад | Хүн ам зүй | Орлогод аажмаар нөлөөлөх | Хүн ам зүйн өөрчлөлттэй холбоотойгоор компанийн орлого буурах | - | Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс нь хүн ам зүйн судалгааг хийх эсвэл томоохон судалгааны байгууллагуудын судалгааг тогтмол ашиглах |
| | Хэрэглэгчдийн хандлага | Орлогод аажмаар нөлөөлөх | Хэрэглэгчдийн хандлага сөргөөр өөрчлөгдөж компанийн орлого буурах | Хэрэглэгчдийн компанийг үнэлэх үнэлэмж, компанид итгэх итгэлийг нэмэгдүүлэх | Бизнес, маркетингийн хэлтэс нь хэрэглэгчдийн хандлагыг тогтмол судлах |
| Гадаад | Харилцагчтай холбоотой | Орлогод аажмаар төлөөлөх | Харилцагчид өөр компаниар үйлчлүүлэх замаар компанийн орлого буурах | Харилцагчид үзүүлж буй үйлчилгээг улам чанаржуулах | Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс нь нэг харилцагчийн компанийн орлогод нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг тооцож, цаашид шаардагдах арга хэмжээг тодорхойлох |
| Гадаад | Нийлүүлэгчтэй холбоотой | Орлогод аажмаар нөлөөлөх | Нийлүүлэгчид өөр компаниудад нийлүүлэлт хийснээр компанийн үйл ажиллагаа доголдох орлого буурах | Нийлүүлэгчидтэй урт хугацааны хамтын ажиллагааг хөгжүүлэх, голлох нийлүүлэгчидтэй урт хугацааны гэрээ байгуулах | Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс нь нэг нийлүүлэгчийн компанийн орлогод нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг тооцож, цаашид шаардагдах арга хэмжээг тодорхойлох |
| Гадаад | Зах зээлд өрсөлдөгчид нэвтрэх | Орлогод аажмаар нөлөөлөх | Шинэ өрсөлдөгчид зах зээлд нэвтэрч зах зээлийг хуваах замаар компанийн орлого буурах | Харилцагчдад үзүүлж буй үйлчилгээний чанарыг сайжруулах | Бизнес, маркетингийн хэлтэс нь өрсөлдөгчдийг судлах, шаардагдах арга хэмжээг боловсруулах |
| Гадаад | Бүтээгдэхүүнийг орлуулах | Орлогод аажмаар нөлөөлөх | Хэрэглэгчид бүтээгдэхүүнийг орлуулах замаар компанийн орлого буурах | Хууль эрх зүйн орчныг сайжруулах, чангатгах замаар орлуулах бүтээгдэхүүнийг зах зээлээс шахах, өөрсдийн үйлчилгээний чанарыг сайжруулах | Бизнес, маркетингийн хэлтэс нь өрсөлдөгчдийг судлах, шаардагдах арга хэмжээг боловсруулах |

<table>
<tr><td>Дотоод</td><td>Үйл ажиллагаа</td><td>Орлогод огцом нөлөөлөх</td><td>Үйл ажиллагааны зохион байгуулалт муутайгаас үүдэн компанийн орлого буурах</td><td>Үйл ажиллагааны зохион байгуулалтыг оновчлох, эргэн харах хугацааг хагас жил тутамд хийх</td><td>Захиргаа, удирдлагын хэлтэс нь үйл ажиллагааны оновчтой байдлыг үнэлж, шаардагдах арга хэмжээ авах</td></tr>
<tr><td>Дотоод</td><td>Боловсон хүчин</td><td>Орлогод аажмаар нөлөөлөх</td><td>Боловсон хүчний дутмаг байдлаас үүдэлтэйгээр компанийн орлого буурах</td><td>Чадварлаг боловсон хүчнийг татахад цалин, хангамжийг сайжруулах, хувьцааны давуу талыг ойлгуулах</td><td>Захиргаа, удирдлагын хэлтэс нь боловсон хүчний үнэлгээ хийж, шаардлагатай арга хэмжээг авах</td></tr>
<tr><td>Дотоод</td><td>Компанийн засаглал</td><td>Орлогод аажмаар нөлөөлөхОрлогод аажмаар нөлөөлөх</td><td>Компанийн засаглал сул байхаас үүдэн компанийн орлого буурах</td><td>Компанийн засаглалын кодексийн дагуу ажиллах</td><td>Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийг хуулийн дагуу томилж, ТУЗ нь сайн компанийн засаглалыг компанид нэвтрүүлэх</td></tr>
<tr><td>Дотоод</td><td>Хөрвөх чадвар</td><td>Орлогод огцом нөлөөлөх</td><td>Санхүүгийн хөрвөх чадвараа хангаж чадаагүйгээс компанийн орлого буурах</td><td rowspan="2">Санхүүгийн шинжилгээг улирал бүр нарийвчлан хийж санхүүгийн төлөвлөлтийг тогтмол хийж байх</td><td rowspan="2">Санхүүгийн хэлтэс нь санхүүгийн шинжилгээний дунд ба ахисан түвшний аргачлалуудыг ашиглан компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах</td></tr>
<tr><td>Дотоод</td><td>Төлбөрийн чадварын</td><td>Орлогод огцом нөлөөлөх</td><td>Санхүүгийн төлбөрийн чадвараа хангаж чадаагүйгээс компанийн орлого буурах</td></tr>
</table>

## ЭРСДЛИЙГ ДААТГАЛЫН КОМПАНИД ШИЛЖҮҮЛЭХ

Өөрсдийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хүрээнд цөөн тохиолддог боловч нэг удаагийн хохирол нь өндөр байдаг эрсдэлүүдийг даатгалын компаниудад хуваан байршуулах нь зүйтэй. Автомашин, ачаа, барилга гэх зэрэг биет хэлбэртэй бөгөөд өндөр үнэлгээтэй, эрсдэлд өртвөл хохирол их амсах хөрөнгүүдийг даатгуулах нь зүйтэй.

Даатгалын компанийг сонгохдоо эрсдэл даах чадварын харьцаанууд болон зах зээлд эзлэх хувь, туршлагыг нь харгалзан үзэх нь зүйтэй. Мөн бүх хөрөнгөө даатгалын нэг компанид даатгуулах нь эрсдэлтэй учир хэд хэдэн компанид тараан байршуулах нь эрсдэлийг давхар бууруулах ач холбогдолтой.